



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 488

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 14 нэрийн, нийт 358,754,727.00 (гурван зуун тавин найман сая долоон зуун тавин дөрвөн мянга долоон зуун хорин долоо) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Увс аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Соёлмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг Увс аймаг, Улаангом сумын Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлж, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132002357
22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Увс аймгийн Улаангом сумын Засаг даргын тамгын газарт
бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Улаангом 3 дугаар багийн 1-36 айлын орон сууцны урд ногоон байгууламжийн гадна тохижилт	багц	1	131,010,218.00	131,010,218.00
2	Сандал	ш	6	134,000.00	804,000.00
3	Лед гэрэлтүүлэг	ш	14	135,000.00	1,890,000.00
4	Хогийн сав	ш	6	120,000.00	720,000.00
5	Бороожуулагч усалгааны систем	кг	17	17,500.00	297,500.00
6	Дуслын систем	ш	90	17,500.00	1,575,000.00
7	Улаангом 3 дугаар багийн Бэл булаг төвийн урд ногоон байгууламжийн гадна тохижилт	багц	1	133,087,578.00	133,087,578.00
8	Сандал	ш	12	134,000.00	1,608,000.00
9	Лед гэрэлтүүлэг	ш	6	135,000.00	810,000.00
10	Хогийн сав	ш	8	120,000.00	960,000.00
11	Бороожуулагч усалгааны систем	кг	17	17,500.00	297,500.00
12	Дуслын систем	ш	90	17,500.00	1,575,000.00
13	Төмөр шонтой, төмөр хүрээтэй, торон хашаа	м	2000	40,942.37	81,884,740.00
14	Навчит модны суулгац 2 настай	ш	332	6,732.50	2,235,191.00
					358,754,727.00
Дүн					(гурван зуун тавин найман сая долоон зуун тавин дөрвөн мянга долоон зуун хорин долоо) төгрөг